



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/139/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом сум 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Ариунсайхан Утас: 70453799, Цахим хаяг: Ariunsaikhant@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.5.3 Нэмэлт төсөв	17
3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	17
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОН	Орон нутаг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ЭЗА	Эдийн засгийн ангилал



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,
Утас/факс: 7045-3317,
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

᠒᠐᠒᠖.᠐᠒.᠐᠔ № УВА-᠒᠐᠒᠖/139/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЦЭРЭНПИЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

8525050075

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



9085585 1626010041

М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	232,550,174.17	314,240,789.20
33	АВЛАГА	25,663.17	
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	25,663.17	
35	БАРАА МАТЕРИАЛ	232,524,511.00	314,240,789.20
354	Хангамжийн материал	197,885,424.00	286,599,035.20
3541	Бичиг хэргийн материал	1,041,400.00	897,700.00
3542	Аж ахуйн материал	50,328,224.00	35,899,919.00
3543	Сэлбэг хэрэгсэл	7,090,000.00	
3547	Бусад хангамжийн материал	139,425,800.00	249,801,416.20
356	Мал амьтад	34,639,087.00	27,641,754.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,223,725,808.51	5,088,073,694.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,223,725,808.51	5,088,073,694.21
392	Биет хөрөнгө	5,181,609,808.63	5,018,355,694.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,248,277,668.68	1,310,837,668.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	-370,774,707.01	-429,485,725.77
39203	Авто-тээврийн хэрэгсэл	257,657,273.00	341,457,273.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-70,517,133.44	-100,126,181.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	305,892,584.56	321,603,444.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	-163,257,971.67	-186,199,677.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,577,186.97	91,465,213.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	-55,474,403.04	-55,414,033.97
39209	Зам, гүүрийн байгууламж	3,827,065,032.00	3,827,065,032.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-667,215,635.16	-824,569,170.12
39214	Бусад үндсэн хөрөнгө	911,077,263.62	941,145,263.62
39215	Хуримтлагдсан элэгдэл	-251,697,349.88	-334,423,412.78
39216	Дуусаагүй барилга, байгууламж	115,000,000.00	115,000,000.00
393	Биет бус хөрөнгө	42,115,999.88	69,718,000.00
39301	Программ хангамж	2,772,000.00	5,772,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,572,000.12	-3,272,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	48,116,000.00	73,418,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-6,200,000.00	-6,200,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,456,275,982.68	5,402,314,483.41
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,502,300.00	50,367,614.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,502,300.00	50,367,614.56
413	Өглөг	2,502,300.00	50,367,614.56
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		34,235,127.56
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		9,495,187.00
4136	Бусад өглөг	2,502,300.00	6,637,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг		6,637,300.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,502,300.00	

V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,453,773,682.68	5,351,946,868.85
51	Засгийн газрын хувь оролцоо	5,453,773,682.68	5,351,946,868.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	653,885,617.77	653,885,617.77
51101	Өмч: - төрийн	653,885,617.77	653,885,617.77
512	Хуримтлагдсан үр дүн	4,501,379,563.03	4,399,815,663.88
5121	Өмнөх үеийн үр дүн	4,501,379,563.03	4,501,642,477.71
5122	Тайлант үеийн үр дүн		-101,826,813.83
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	298,508,501.88	298,245,587.20
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,456,275,982.68	5,402,314,483.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,824,545,559.00	1,495,859,969.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	467,239,380.00	446,951,362.13
120	Нийтлэг татварын бус орлого	467,239,380.00	446,951,362.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	467,239,380.00	7,750,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,100,000.00	7,750,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	462,139,380.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		229,728,491.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		209,472,870.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,357,306,179.00	1,048,908,606.99
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	268,734,679.00	5,763,749.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	252,088,062.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,646,617.00	3,763,749.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,088,571,500.00	1,043,144,857.99
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,088,571,500.00	1,043,144,857.99
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,578,901,089.21	1,595,544,783.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,578,901,089.21	1,595,544,783.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,493,281,778.90	1,592,986,960.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	730,950,372.00	817,909,639.61
210101	Үндсэн цалин	426,285,169.16	424,756,728.80
210102	Нэмэгдэл	264,038,022.10	334,975,632.55
210104	Урамшуулал		16,258,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,627,180.74	41,918,478.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,506,974.51	101,745,233.46
210201	Тэтгэврийн даатгал	61,926,771.76	69,356,888.11
210202	Тэтгэмжийн даатгал	7,318,688.12	8,163,905.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,213,023.69	4,697,171.25

210204	Ажилгүйдлийн даатгал	3,080,244.25	4,180,048.12
210205	Эрүүл мэндийн даатгал	12,968,246.69	15,347,220.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,890,567.13	51,114,165.47
210301	Гэрэл, цахилгаан	9,430,892.85	14,035,678.47
210302	Түлш, халаалт	39,459,674.28	37,078,487.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,827,981.50	51,759,159.00
210401	Бичиг хэрэг	5,064,560.00	2,268,700.00
210402	Тээвэр, шатахуун	27,758,957.50	36,995,044.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,277,000.00	2,570,410.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	707,900.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,019,564.00	9,925,005.00
2105	Нормативт зардал		600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,947,000.00	14,685,500.00
210604	Урсгал засвар	2,947,000.00	14,685,500.00
2107	Томилолт, зочны зардал	12,640,000.00	9,110,000.00
210702	Дотоод албан томилолт	12,640,000.00	9,110,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,518,809.00	1,409,377.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,815,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	158,400.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,149.00	329,637.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	
210807	Газрын төлбөр	557,060.00	676,540.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	545,000,074.76	544,653,885.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	216,720,117.50	171,265,579.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	326,279,957.26	373,388,306.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,619,310.31	2,557,823.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,729,514.00	550,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,551,789.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,177,725.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	550,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,548,167.31	7,801.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,548,167.31	7,801.18
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,341,629.00	2,000,022.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,341,629.00	2,000,022.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	245,644,469.79	-99,684,814.25
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	242,066.78	2,141,999.58
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	242,066.78	

225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		2,141,999.58
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-242,066.78	-2,141,999.58
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	245,402,403.01	-101,826,813.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,362,406,179.00	1,056,658,606.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,100,000.00	7,750,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,100,000.00	7,750,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,100,000.00	7,750,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,100,000.00	7,750,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,357,306,179.00	1,048,908,606.99
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	268,734,679.00	5,763,749.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	252,088,062.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,646,617.00	3,763,749.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,088,571,500.00	1,043,144,857.99
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,088,571,500.00	1,043,144,857.99
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,111,521,117.00	1,046,508,906.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,111,521,117.00	1,046,508,906.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,025,901,806.69	1,042,751,083.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	730,343,581.16	801,616,982.80
210101	Үндсэн цалин	425,688,803.98	414,253,440.45
210102	Нэмэгдэл	264,027,595.75	330,122,972.09
210104	Урамшуулал		16,259,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,627,181.43	40,981,470.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,139,428.52	83,777,099.54
210201	Тэтгэврийн даатгал	62,801,390.06	57,764,118.36
210202	Тэтгэмжийн даатгал	7,318,688.12	6,643,158.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,938,588.34	3,685,857.52
210204	Ажилгүйдлийн даатгал	3,163,191.85	3,164,944.51
210205	Эрүүл мэндийн даатгал	12,917,570.15	12,519,020.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,190,567.13	44,328,978.47
210301	Гэрэл, цахилгаан	9,430,892.85	14,035,678.47
210302	Түлш, халаалт	35,759,674.28	30,293,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,709,598.88	21,722,364.00
210401	Бичиг хэрэг	3,513,300.00	1,696,000.00
210402	Тээвэр, шатахуун	20,972,846.00	16,221,154.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,297,552.88	2,570,410.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	707,900.00	156,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,218,000.00	1,077,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,485,000.00	7,595,500.00
210604	Урсгал засвар	2,485,000.00	7,595,500.00
2107	Томилолт, зочны зардал	10,393,700.00	8,902,300.00
210702	Дотоод албан томилолт	10,393,700.00	8,902,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,618,809.00	1,409,377.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,815,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	158,400.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	263,149.00	329,637.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	
210807	Газрын төлбөр	557,060.00	676,540.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,021,122.00	73,398,482.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,021,122.00	72,848,482.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	550,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,619,310.31	3,757,823.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,729,514.00	1,750,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,551,789.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,177,725.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,548,167.31	7,801.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,548,167.31	7,801.18
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,341,629.00	2,000,022.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,341,629.00	2,000,022.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	250,885,062.00	10,149,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		10,149,700.00
	Дотоод эх үүсвэрээр		10,149,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		10,149,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-10,149,700.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	250,885,062.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	653,885,617.77	298,508,501.88	4,256,077,160.12	5,208,471,279.77
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	653,885,617.77	298,508,501.88	4,256,077,160.12	5,208,471,279.77
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00

C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	245,302,402.91	00.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	653,885,617.77	298,508,501.88	4,501,379,563.03	5,453,773,682.68
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	653,885,617.77	298,508,501.88	4,501,379,563.03	5,453,773,682.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	262,914.68	262,914.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-262,914.68	00.00	-262,914.68
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-101,826,813.83	-101,826,813.83
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	653,885,617.77	298,245,587.20	4,399,815,663.88	5,351,946,868.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,188,553,000.00	1,050,887,056.81	137,665,943.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,188,553,000.00	1,054,650,783.81	133,902,216.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,185,553,000.00	1,052,900,783.81	132,652,216.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	830,063,800.00	801,616,982.80	28,446,817.20
210101	Үндсэн цалин	786,119,600.00	414,253,440.45	371,866,159.55
210102	Нэмэгдэл		330,122,972.09	-330,122,972.09
210104	Урамшуулал	200,700.00	16,259,100.00	-16,058,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	43,743,500.00	40,981,470.26	2,762,029.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,575,500.00	83,777,099.54	19,798,400.46
210201	Тэтгэврийн даатгал	70,428,000.00	57,764,118.36	12,663,881.64
210202	Тэтгэмжийн даатгал	8,285,500.00	6,643,158.37	1,642,341.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,141,900.00	3,685,857.52	456,042.48
210204	Ажилгүйдлийн даатгал	4,142,600.00	3,164,944.51	977,655.49
210205	Эрүүл мэндийн даатгал	16,577,500.00	12,519,020.78	4,058,479.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,368,000.00	44,328,978.47	11,039,021.53
210301	Гэрэл, цахилгаан	22,950,500.00	14,035,678.47	8,914,821.53
210302	Түлш, халаалт	32,417,500.00	30,293,300.00	2,124,200.00

2104	Хангамж, бараа материалын зардал	26,644,400.00	21,722,364.00	4,922,036.00
210401	Бичиг хэрэг	2,701,800.00	1,696,000.00	1,005,800.00
210402	Тээвэр, шатахуун	14,530,500.00	16,221,154.00	-1,690,654.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,025,900.00	2,570,410.00	455,490.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,500,000.00	156,900.00	4,343,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,886,200.00	1,077,900.00	808,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,692,100.00	14,745,200.00	2,946,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,649,700.00	7,149,700.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	8,042,400.00	7,595,500.00	446,900.00
2107	Томилолт, зочны зардал	9,228,900.00	8,902,300.00	326,600.00
210702	Дотоод албан томилолт	9,228,900.00	8,902,300.00	326,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,210,900.00	4,409,377.00	1,801,523.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	672,700.00		672,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00	
210803	Даатгалын үйлчилгээ	275,000.00		275,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,000.00	329,637.00	270,363.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	230,000.00		230,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,000,000.00	
210807	Газрын төлбөр	1,030,000.00	676,540.00	353,460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136,769,400.00	73,398,482.00	63,370,918.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	133,669,400.00	72,848,482.00	60,820,918.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,100,000.00	550,000.00	2,550,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	1,750,000.00	1,250,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	1,750,000.00	1,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	1,750,000.00	1,250,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,178,553,000.00	1,043,137,056.81	135,415,943.19
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	7,750,000.00	2,250,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	7,750,000.00	2,250,000.00
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	
3	Төсвийн байгууллага	1	1	
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	29	29	
6	Удирдах ажилтан	8	8	
7	Гүйцэтгэх ажилтан	10	10	
8	Үйлчлэх ажилтан	3	3	
9	Гэрээт ажилтан	8	8	
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	29	
25	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	

34	Гэрээт ажилтан	4	4
35	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,763,727.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,763,727.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,763,727.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,029,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,029,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,313.00
210201	Тэтгэврийн даатгал	118,313.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,616,414.00
210402	Тээвэр, шатахуун	2,616,414.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,763,749.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,763,749.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,763,749.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газар нь Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажилладаг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ;
- худалдан авах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
- Төрийн албаны тухай хуульд – 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- Төсвийн тухай хуульд - 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн "CTSYSTEM 6.0.5" программ ашиглан бэлтгэж, сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,961.5 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	25.7	0.0	-25.7
Бараа материал	232,524.5	314,240.8	81,716.3
Үндсэн хөрөнгө	5,223,725.8	5,088,073.7	-135,652.1
Нийт хөрөнгө	5,456,276.0	5,402,314.5	-53,961.5
Өр төлбөр	2,502.3	50,367.6	47,865.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,453,773.7	5,351,946.9	-101,826.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,456,276.0	5,402,314.5	-53,961.5

Мөнгөн хөрөнгийн данс тайлант оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 314,240.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 81,716.3 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар ирсэн бараа материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,088,073.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 135,652.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тооцсон 373,388.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал, 23,549.3 мянган төгрөгийн хөрөнгө акталсан нь гол нөлөө үзүүлжээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 50,367.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 47,865.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны төсвийн таналттай холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэл, түлш халаалт, албан томилолтын өглөгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,351,946.9 мянган төгрөг болж, 101,826.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,213,285.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 24,732.6 мянган төгрөгөөр бууруулж, 1,188,553.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,188,553.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,178,553.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,043,137.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 7,750.0 мянган төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 1,050,887.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,050,887.1 мянган төгрөг буюу 88.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны орлого 2,250.0 мянган төгрөгөөр дутуу бүрдэж, зардлыг 2,000.0 мянган төгрөг хэмнэж төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Үндсэн үйл ажиллагааны зардал	688,061.5	654,588.3	33,473.2	95.1%
2	70106-80106- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-баг хорооны Үйл ажиллагааны зардал	226,975.4	206,470.0	20,505.4	91.0%
3	70106-80111- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	53,850.3	45,077.8	8,772.5	83.7%
4	70106-80112- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Нийтлэг үйлчилгээ	77,996.4	69,995.6	8,000.8	89.7%
5	70106-80205- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Мэдээлэл сурталчилгааны зардал	500.0	0.0	500.0	0.0%
6	70106-80802- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- ажил олгогчоос олгох тэтгэмж	3,000.0	1,750.0	1,250.0	58.3%
7	70106-81102- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Орон нутгийн нөөц хөрөнгө	31,322.0	21,685.5	9,636.5	69.2%
8	70106-81507- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Мал тооллого	750.0	0.0	750.0	0.0%
9	70106-82212- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Хур хог хаягдал орчны бохирдол	4,500.0	156.9	4,343.1	3.5%
10	70106-82801- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Улсын баяр наадам	5,000.0	5,000.0	0.0	100.0%
11	71413-81701- Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх- Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх-	95,997.4	45,563.0	50,434.4	47.5%
12	72208-81549- Ахмад настны хөгжил хамгаалал- Ахмадын сан	600.0	600.0	0.0	100.0%

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	3,000.0	3,000.0	Тайлант онд CTSYSTEM 6.0.5 программыг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. АХЭЦЭН
2	Унаа, хоолны зарцуулалт			Зардал гараагүй
3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал	2,550.0	550.0	Шинээр томилогдсон багийн Засаг дарга нарт сургалт хийсэн.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	-	-	Зардал гараагүй
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	-	Зардал гараагүй
6	Орон тоо	830,063.8	801,617.0	2025 онд 29 орон тоо батлагдсан бөгөөд удирдах 8, гүйцэтгэх 10, үйлчилгээний 11 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өмнөговь сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,763.7 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,000.0 мянган төгрөгийн орлого бүрдсэн бөгөөд 3,763.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газарт тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 онд 7,149.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,000.0 мянган төгрөгөөр программ хангамж шууд худалдан авалт хийсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-

ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Ариунсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,579,001.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 15,790.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 12,632.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,567,903.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 15,679.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 12,543.2 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-т “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.”, Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолоор төрийн байгууллагын тээврийн хэрэгсэлтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан заасан байна. Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд 341,457.3 мянган төгрөгийн 13 автотээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 9 автотээврийн хэрэгсэл тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна. Үүнээс 6 автотээврийн хэрэгслийг актлах санал хүргүүлсэн, 1 автотээврийн хэрэгслийг актлах санал хүргүүлэх бэлтгэл ажил хангаж байгаа, 1 автотээврийн хэрэгслийн бичиг баримтын зөрчилтэй, 1 автотээврийн хэрэгслийг тайлант онд хүлээж аваад авто машины улсын үзлэгт оруулаагүй шалтгаанаар дээрх автотээврийн хэрэгслүүд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй байна. Иймд төсвийн захирагчийн зүгээс хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг эрчимжүүлэхийг зөвлөлөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 168, хугацаа хоцроосон 1, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өмнөговь сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хагас жилийн мал тооллогын гэрээт ажлын цалин 1,029.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тусгаагүй орхигдуулсан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “үнэн зөв байх” зарчмыг баримтална, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.7 дэх заалтад “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах” гэж заасан хууль тогтоомжийн заалт хангагдахгүй байх эрсдэл үүсэх магадлалтай тул дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,645.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 5,645.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 2,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаагүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т аж ахуйн нэгж, байгууллага нь “үнэн зөв байх” зарчмыг баримтална, 14 дүгээр зүйлийн 14.4.5-т нягтлан бодох бүртгэлд “бүх орлого”-ыг заавал бүртгэнэ гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин урамшуулалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Батлагдсан бүтцэд байхгүй хогны асуудал хариуцсан мэргэжилтэн, олон нийтийн цагдаа гэсэн орон тоонд ажилтан томилж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан тайлант онд нийт 5,645.5 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг хэрэгжүүлэн батлагдсан бүтэц, орон тоонд багтаан ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа-гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаагүй.	1	2,000.0	1	2,000.0			1	2,000.0				
Дүн	1	2,000.0	1	2,000.0			1	2,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдсан бүтцэд байхгүй орон тоонд ажилтан томилж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан нийт 5,645.5 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна							1	5,645.5				
Дүн							1	5,645.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.АРИУНСАЙХАН/

2026.02.04